



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 44

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Хулд сумын Эрүүл мэндийн төв болон Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 48,792,050 /дөчин найман сая долоон зуун ерэн хоёр мянга тавин/ төгрөгийн балансын үнэ бүхий, 4,879,204.92 /дөрвөн сая найман зуун далан есөн мянга хоёр зуун дөрвөн төгрөг ерэн хоёр мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэлтэй 2 нэр төрлийн тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг Хулд сумын Эрүүл мэндийн төв /Э.Уранчимэг/, ЗДТГ /С.Сүхдорж/-т, бүртгэж авахыг Соёлын төв /Г.Сүхтөмөр/, Эрүүл мэндийн төв /Э.Уранчимэг/-д тус тус даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаярт/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Р100036

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны ...  
сарын ... өдрийн ..... дугаар тогтоолын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Эзэмшигч байгууллага	Хөрөнгийн нэр	Улсын дугаар	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлж авах байгууллага
1	Хулд сумын ЭМТ	УАЗ-220692-033 0 автомашин	98-66 ДУА	2015-12-10	10,000,000	999,999.96	9,000,000.04	Хулд сумын Соёлын төв
2	Хулд сумын ЗДТГ	УАЗ-Патриот автомашин	64-16 ДУА	2015-12-18	38,792,050	3,879,204.96	34,912,845.04	Хулд сумын ЭМТ
Дүн					48,792,050	4,879,204.92	43,912,845.08	